

“ХӨВСГӨЛ АЛТАНДУУЛГА” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2026 оны 04 дүгээр сарын 10

Хөвсгөл аймаг, Тариалан сум

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 11:15 цагт Хөвсгөл аймгийн Тариалан сумын Мандал багт байрлах тус компанийн байранд эхлэв.

Хурал зохион байгуулах комиссын дарга Г.Бат-Эрдэнэ: 2026 оны 02 дугаар сарын 25-ны өдөр хуралдсан компанийн ТУЗ-ийн хурлаас Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах шийдвэр гаргасан ба хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаар ТУЗ-ийн дарга Д.Батхуягийг, Тооллогын комиссын даргаар Б.Юмжирдулам, гишүүдээр Б.Сарангарав, Б.Энхмөрөн нарыг томилсон байна.

Хурлын дарга Д.Батхуягийг хурал удирдахыг урьж байна.

Д.Батхуяг: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Одоо Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэгийг танилцуулъя.\ дэгийг танилцуулав\

ТУЗ-ийн шийдвэрээр байгуулагдсан Тооллогын комисс хурлын ирцийг гаргаж, тооллогын комиссын тогтоолыг танилцуулна.

Б.Юмжирдулам: Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс 2026 оны 03 сарын 17-ны өдрөөр тасалбар болгон авсан бүртгэлээр тус компанийн нийт хувьцаа эзэмшигч: 514, Хувьцааны тоо : 15 734 200 байна. Үүнээс “Хөвсгөл Алтан дуулга” ХК-ийн халаасны хувьцаа 783,545 ширхэг байна.

“Хөвсгөл Алтан дуулга” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд 8,004,587 ширхэг энгийн хувьцаа эзэмшиж буй 10 хувьцаа эзэмшигч оролцож, 2,806,047 ширхэг энгийн хувьцаа эзэмшиж 7 хувьцаа эзэмшигч урьдчилан саналаа ирүүлсэн байна. Саналын эрх бүхий 14,950,655 \нийт 15,734,200 ширхэг хувьцаанаас компанийн халаасны хувьцаа болох 783,545 ширхэг хувьцааг хассан дүн\ ширхэг энгийн хувьцаанаас 10,817,824 ширхэг хувьцаа эзэмшиж буй 17 хувьцаа эзэмшигч оролцсон нь 72,36 хувь болж байгааг мэдэгдье.

\Хурлын ирцийн тухай Тооллогын комиссын тогтоолыг хавсаргав\

Д.Батхуяг:Хурлын ирц хуульд заасан шаардлагад хүрсэн тул Хувьцаа эзэмшигчдийн хурлыг эхлэе.

Өнөөдрийн хуралд компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Энхтогтох, ердийн гишүүн М.Зулзаяа, мөн миний бие, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга С.Оюунгэрэл нар оролцож байна. Мөн компанийн гүйцэтгэх удирдлагын багын гишүүд оролцож байгааг мэдэгдье.

ажлыг өөрсдийн хүчээр хийж байна. Бүтээгдэхүүний сав баглаа боодол, шуудайг шинэчилсэн. 1кг-ийн хэмжээтэй гурилын савлагааг амжилттай нэвтрүүлсэн нь хэрэглэгчдийн ташаалд нийцсэн чухал ажил болсон. Бүтээгдэхүүний сурталчилгаа, маркетинг дээр анхаарч ажилласан. Улаанбуудай цэвэрлэх тоног төхөөрөмжийг бүгдийг суурилуулсан. Хаврын тариалалтанд хэрэглэх үрийн буудайн цэвэрлэгээг бүрэн хийсэн. Үйлдвэрийн хашаанд нийт 16 камерыг шинээр суурилуулсан. Нийтдээ 29 хяналтын камер ажиллаж байна. Төв зам дагуу байгаа сурталчилгааны самбаруудыг шинэчилж байрлуулсан. 2026 онд бэлэн бүтээгдэхүүний агуулахыг шинээр барина. Зураг төслийг гаргуулсан. Байгууллагынхаа ерөнхий зураг, планыг шинэчлэн гаргуулж байна.

2026 оны гол зорилтууд:

-Бага га-гаас өндөр ургац авах. ОХУ-аас гарц өндөртэй, эрт болцын шинэ сортын үр тариаг туршилтаар тарихаар төлөвлөж байна.

- Хөрс хамгаалах, хүнсний үршил шимийг сайжруулах шинэ технологийг нэвтрүүлэх
- Технологи нэвтрүүлэхтэй холбоотой техникийн шинэчлэлийг хийнэ.
- Технологийн ажилд оролцогч оператор, агрономич нарын ажлын гүйцэтгэлийн чанар, үр дүнд тулгуурлан цалин хөлс, урамшууллыг олгодог системийг бий болгох
- Тариалалтын бүх талбайг хашаажуулж дуусгах
- Компанийн хэмжээнд нэгжүүдийн ажлын уялдаа холбоог сайжруулах үйл ажиллагааны болон санхүүгийн дотоод хяналтын системийг бүрдүүлж, баг байгуулан ажиллах
- Итгэмжлэгдсэн лабораторийг дахин итгэмжлүүлж, хорио цээрийн лабораторийн ажлын хүрээг өргөтгөн, хүний нөөцийг чадавхжуулж ажиллана.

Гурилын үйлдвэрлэлийн чиглэлд:

- Үйлдвэрлэлийн процессыг хагас автоматжуулсан горимд шилжүүлэн, санхүүгийн нөөц боломжид тулгуурлан хэсэгчилэн шийдэрлэж ажиллана.
- Үйлдвэрийн чанар, эрүүл ахуй MNS ISO 9001:15 стандартыг бүрэн хангахад нийцүүлэн барихаар төлөвлөсөн Агуулахын өргөтгөлийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх, санхүүгийн эх үүсвэрийг олох
- Тэжээлийн үйлдвэрлэлийн орчин үеийн техник технологийг судалж, төсөл хөтөлбөр боловсруулах, төсөлд хамрагдах. Холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, бүс нутаг дахь малын тэжээлийн зах зээлд томоохон байр суурь эзлэх гэсэн зорилтуудыг тавилаа.

2026 онд санхүүгийн нийт орлого: 25,770тэрбум, нийт ашиг 7,283 тэрбум, ерөнхий үйл ажиллагааны цэвэр ашиг 3,2668 тэрбум төгрөг, татварын дараах цэвэр ашиг 1,820 тэрбум төгрөг байхаар төлөвлөв. Газар тариалангийн хувьд нийт уринш хийх талбай 187 га, ажиллагсдын тоо 22 байна. 1405 га-д тариалалт хийх, үүнд улаан буудай 1266 га-д, бусад үр тариа 139 га-д тариална. Га-гаас авах ургацын хувьд улаан буудай 30 цн байна. Нийт 4005 цн ургац авахаар төлөвлөв. Гурилын үйлдвэрийн хувьд: Нийт 13676 тн буудай тээрэмдэнэ. 1-р ба дээд гурил 9729 тн, 2,3-р гурил 580 тн, бүхэл үрийн гурил 322 тн, хивэг 3045 тн үйлдвэрлэнэ. Гурилын үйлдвэрт 32 ажилтан, ажилчид ажиллана.

2026 оны нийт зардлын төсөв: Газар тариалангийн зардал: 2,059,136,002 төг, Боловсруулах үйлдвэрлэлийн зардал 15,471,000,000 төг, борлуулалтын зардал 441,288,375 төг, ерөнхий удирдлагын зардал 2,757,157,332 төг, Санхүүгийн зардал 1,279,000,000 төг, үндсэн хөрөнгө худалдан авалтын зардал 1,921,800,000 төгрөг байхаар төсөвлөлөө. Хөрөнгө оруулалтын төсөв 1,921,800,000 төгрөг байхаар тооцлоо. Бэлэн бүтэгдэхүүний агуулах барихад 1,5 тэрбум, 200 ш поддон авахад 65 сая, Силосны хүлээн авахад шаардлагатай цэвэрлэгээний төхөөрөмж авахад 280 сая төгрөг төсөвлөлөө.

Д.Батхуяг: Бат-Эрдэнэ захирлын танилцуулгаас асууж, тодруулах зүйл байна уу. Байхгүй байна. Дараагийн асуудалдаа орёё.

Хэлэлцсэн нь: Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Танилцуулах нь: Д.Энхтогтох: ТУЗ-ийн гишүүн, Аудитын хорооны дарга \ ТУЗ-ийн дүгнэлтийг материалд хавсаргав \

Д.Энхтогтох: Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангаас “газар тариалан болон боловсруулах үйлдвэрт хийгдсэн технологийн болон өргөжүүлэх, засварлах замаар чанарыг сайжруулах чиглэлийн ажлууд”-ын явц үр дүн, санхүүгийн байдалтай танилцав.

Үйл ажиллагааны тайланд дурьдсан боловсруулах үйлдвэрийн зарим шат дамжлагууд, чанарын лаборатори, газар тариалангийн үйлдвэрлэл дэх өргөжүүлсэн, засварласан ажлууд бүтээгдэхүүний өртөг зардлыг бууруулах, хүний хүчин зүйлийн оролцоог эерэг талаас нь дэмжсэн чухал ажил болсон байна.

2025 онд “үйл ажиллагааны чиглэл тус бүрээр буюу нэгж бүр төлөвлөлт, хүлээж буй үр дүн, гүйцэтгэлийг зэрэгцүүлсэн байдлаар хэмжиж дүгнэж, харьцуулахуйц, динамик байдлаар тодорхойлж, нэгтгэлийн доторх тоонууд “ямар үр дүн, өгөөжтэй эсэх”-ийг танилцуулж байхыг зөвлөсөн, энэ ажлыг цаашид хэвшүүлэн, чухалчлан авч үзэхийг компанийн гүйцэтгэх захирал Г.Бат-Эрдэнэ, ерөнхий нягтлан бодогч Ж.Отгонням нарт үүрэг болгож байна.

Газар тариалан болон боловсруулах үйлдвэрт уламжлалт нэр төрлийг баяжуулан, орлого бүхий үйлчилгээ, бүтээгдхүүн, шинээр бий болгох, үр өгөөжийг хүртээмжтэй болгох чиглэлийн ажлууд зохион байгуулан ажилласан байна.

Үйл ажиллагаа болон санхүүгийн гол үзүүлэлтүүдийг графикаар зэрэгцүүлж дэлгэцэн дээр үзүүлж байгааг Та бүхэн анхаарна уу.

Үйлдвэрлэлийн барилга, талбай, тоног төхөөрөмжийн шинэчлэл өргөтгөл нь зах зээл дээр тогтвортой байдлаа хангах, стратегийн нөөцөө арвижуулж, үйлдвэрлэлийн хүчин чадал ашиглалтыг нэмэгдүүлэх зэрэгт чухал хөрөнгө оруулалт болсон байна.

Эдгээр хуримтлагдсан нөөцдөө тулгуурлан “ирэх онд орлого болон ашгийг 2-3 дахин нэмэгдүүлэх”-ээр гүйцэтгэх удирдлагын баг төлөвлөснийг сайшааж, аливаа асуудлыг олон талаас нээлттэй хэлэлцэн үр дүндээ хүрэхийг зөвлөж байна. ТУЗ-ийн зүгээс компанийн үйл ажиллагааг “Хангалттай” дүгнэж байна.

Д.Батхуяг: Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой асуух асуулт байна уу?

Асуулт байхгүй байна.

Үг хэлэх, санал гаргах хүн байна уу? Байхгүй байна. За дараагийн асуудалдаа орёё.

Хэлэлцсэн нь: ТУЗ-ийн 2026 оны зардлын төсвийн талаар

Танилцуулсан нь: Д.Батхуяг

Та бүхэнд ХЭХ-аар хэлэлцэх асуудлуудыг ном хэлбэрээр хувилж тараасан. Танилцсан байх. ТУЗ-ийн 2026 оны зардлын төсвийг 153, 777,180,00 төгрөгөөр батлуулах саналтай байна. ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшуулал, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын цалинд өөрчлөлт орсон. Бусад зардал өмнөх оны хэмжээнд байгаа.

Асуулт байна уу? Байхгүй байна. Дараагийн хэлэлцэх асуудалдаа орёё.

Хэлэлцсэн нь: ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай

Танилцуулсан нь: Д.Батхуяг

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4, 79 дүгээр зүйлийн 79.1 дэх заалтыг үндэслэн “Хөвсгөл Алтандуулга” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүдийг сонгон шалгаруулах тухай зарыг компанийн пэйж хуудсаар дамжуулан хүргэсэн. Энэ зарын дагуу 03 сарын 23-ны өдрөөс 04 сарын 03-ны өдрийн хугацаанд компанийн хараат бус гишүүнээр ажиллах хүсэлтээ илэрхийлж зарим хүмүүс материалаа мэйл-р ирүүлсэн байна. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо нь 2026 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр хуралдаж компанийн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвших материалаа ирүүлсэн хүмүүсийн асуудлыг хэлэлцсэн байна. Нэр дэвшүүлэх хороо нь Хараат болон Ердийн гишүүнд нэр дэвшүүлэх асуудлыг нэгтгэн хорооныхоо хурлаар хэлэлцэх журамтай. Тус хурлаас ТУЗ-ийн гишүүнд дараах хүмүүсийг нэр дэвшүүлэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр санал ирүүлжээ.

Хараат бус гишүүд нэр дэвшигчид:

1.Пүрэвийн Баянсан- МУИС-ийн Бизнесийн сургуулийн ахлах багш, санхүүч мэргэжилтэй, Бизнесийн удирдлагын доктор, боловсролын доктор, 49 настай, эрэгтэй, улсад ажилласан жил 27

2.Пүрэвийн Бат-Оргил- “Грийн сайлос” ХХК-ийн Гүйцэтгэх захирал, Механик инженер мэргэжилтэй, бизнес ба удирдахуйн ухааны магистр, 44 настай, эрэгтэй, улсад ажилласан жил 18

3.Ширэндэвийн Энхмэнд- “Хос Алтайн цамхаг” ХХК-ийн зөвлөх, бизнесийн менежментийн мэргэжилтэй, 39 настай, эмэгтэй, улсад ажилласан жил 21

4.Цэдэвийн Наран-Учрал- “Тэлмэн ресурс” ХХК-ийн Гүйцэтгэх захирал, Олон улсын эдийн засагч мэргэжилтэй, 37 настай, улсад ажилласан жил 16

5.Даваажавын Энхтогтох- “Хараа хөвч хангай” ХХК-ийн Гүйцэтгэх захирал, эдийн засагч, нягтлан бодогч, статистикч мэргэжилтэй, 64 настай, эмэгтэй, улсад ажилласан жил 44

6. Очирхүрээгийн Тунгалаг- “Тунгаамал төв” ТББ-ын Гүйцэтгэх захирал, эрх зүйч, хууль зүйн магистр, 69 настай, эмэгтэй, улсад ажилласан жил 36

Тавьсан шаардлагын хувьд:

1.Бакалавр, түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх;

2.Мэргэжлийн чиглэл: Эдийн засагч, Санхүүч, Аудитор, Инженер, Эрх зүйч, Бизнесийн удирдлага;

3.Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил, үүнээс удирдах албан тушаалд 2-аас доошгүй жил ажилласан бол давуу тал болно;

4.Шүүхийн шийдвэрээр тогтоогдсон хугацаа хэтэрсэн өр төлбөргүй;

5.Өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны таваас дээш хувийг эзэмшдэггүй;

6.Өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид ажил, албан тушаал эрхэлдэггүй, эсхүл сүүлийн 3 жилийн хугацаанд ажил, албан тушаал эрхэлж байгаагүй;

7.Төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй;

8.Компанитай бизнесийн аливаа холбоогүй байх ёстой юм байна.

ТУЗ-ийн энгийн гишүүнд нэр дэвшүүлж байгаа 6 хүнийг танилцуулъя.

1.Доржпүрэвийн Батхуяг- “Хөвсгөл Алтандуулга” ХК-ийн ТУЗ-ийн дарга, эрх зүйч, 57 настай, эрэгтэй, ажилласан жил 33, Тэс группийг үүсгэн байгуулагч

2.Лхамын Даваа- ХААИС, АЭС-ийн багш, агрономич, доктор, дэд профессор, Монгол Улсын Зөвлөх агрономич, 61 настай, эрэгтэй, улсад ажилласан жил 39

3.Доржпүрэвийн Дуламсүрэн- “Алтан Хажир” ХХК-ийн зөвлөх, багш мэргэжилтэй, эмэгтэй, улсад ажилласан жил 32, 2012-2022 оныг хүртэл Хөвсгөл Алтандуулга ХК-ийн гүйцэтгэх захирлаар ажилласан.

4.Мандширын Зулзаяа- Эрх зүйч мэргэжилтэй, хуульч, өмгөөлөгч, 42 настай, эмэгтэй, улсад ажилласан жил 20

5.Мөнх-Эрдэнийн Золзаяа- “Ашихай” ХХК-ийн гүйцэтгэх захирал, Зочид буудлын менежмент, бизнесийн удирдлага, 36 настай, эмэгтэй, улсад ажилласан жил 12

6.Батхуягийн Мандхай- “Модерн кастл Модифар” ХХК-ийн гүйцэтгэх захирал, менежментийн удирдлага, 27 настай, эмэгтэй, улсад ажилласан жил -2

Саналын хуудас болон, санал өгөхтэй холбоотой зааварчилгааг Тооллогын комиссоос өгөх болно.

Танилцуулгаас асуух зүйл байна уу? Байхгүй байна.

Хэлэлцсэн нь: ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын тухай

Танилцуулсан нь: Д.Батхуяг:

Хувьцаа эзэмшигчдийн 2018 оны хурлаас “ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын тухай” 04 тоот тогтоол гаргаж баталсан бөгөөд энэ тогтоолыг мөрдөж ажилласаар ирсэн юм. Компанийн тухай хуулийн 62.1.13 дахь заалт, “Хөвсгөл Алтандуулга” Хувьцаат Компанийн дүрмийн 7.8.7, 7.44 дэх заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 145 дугаар тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ийн 6.1 дэх хэсэг заасны дагуу Тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшуулалыг Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурал, хороодын хуралд оролцсон оролцоо, тодорхой асуудлаар байгуулагдсан ажлын хэсэгт ажилласан байдал зэргийг үндэслэн олож байх, мөн компанитай гэрээ, хэлцэл хийж гүйцэтгэсэн ажлын урамшууллыг тухайн гэрээ, хэлцлийн дагуу олгож байхаар төлөвлөлөө. Энэ удаагийн хурлаар ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг бага хэмжээгээр нэмэгдүүлсэн.

\Асуух асуулт, санал гараагүй болно.\

Танилцуулсан нь: Ногдол ашиг хуваарилахгүй байх тухай ТУЗ-ийн тогтоолын талаар Д.Батхуяг: Ногдол ашиг хуваарилахгүй байх тухай ТУЗ-өөс гаргасан тогтоолыг Хувьцаа Хувьцаа эзэмшигчдэд танилцуулах ёстой. Ногдол ашиг хувиарлахгүй болсон шалтгаан, үндэслэлээ Гүйцэтгэх захирал ТУЗ-ийн хуралд танилцуулсаны үндсэн дээр ТУЗ-өөс шийдвэр гаргасан.

“Хөвсгөл Алтан дуулга” ХК нь 2025 онд зах зээлд гурилын хамгийн хямд үнийг хэрэглэгчдэд санал болгох, орон нутаг дахь тэжээлийн борлуулалтыг бүрэн хийх, 1кг-ийн гурилын жижиглэнгийн автомат савлагааг үйлдвэрлэлд нэвтрүүлэн, тоног төхөөрөмжийг угсрах, компанийн дэргэдэх ургамал хорио цээрийн лабораторийн шинжилгээний аппарат, тоног төхөөрөмжийг нэмж суурилуулах зэрэг ажлуудыг хийсэн нь компанийн үйл ажиллагааг жигд тогтвортой явуулахад ач холбогдолтой болсон байна. Дээрх ажлын үр дүнд борлуулалтын орлогыг 15 хувь, өртгийг 14 хувиар нэмэгдүүлж, 2025 оны жилийн эцсийн тайлангаар 206 гаруй сая төгрөгийн ашигтай ажилласан юм. Цаашид хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг бага эрсдэлтэй, үр өгөөжтэй байлгах, эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн хүчин чадлыг өсгөх, компанийн үйл ажиллагааг илүү тогтвортой болгох зайлшгүй шаардлагатай байгаа.

Ер нь бол Хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг хувиарлахгүй байгаа асуудалдаа дүгнэлт хийж байгаа. Хувьцааны ханш анх байсан хэмжээнээсээ бага, багаар доошилсоор байгаа. Хувьцааны ханшаа аажмаар нэмэгдүүлэхэд анхаарна. Төрийн банкнаас авсан зээл, УИХ-аас импортын гурилыг оруулж ирэх шийдвэр гаргасан асуудал, төрөөс үндэсний үйлдвэрлэлийг дэмжинэ гэдэг боловч тэр бүр энэ шийдвэр нь бодитоор хэрэгжихгүй байгаа явдал, байгаль, цаг уурын хараат байдал зэргээс шалтгаалан компанийн эдийн засаг, санхүүгийн байдалд ахиц гарахгүй байгааг Та бүхэн ойлгож байгаа байх. Томоохон хувьцаа эзэмшигчийн хувьд ногдол ашгаа хүртэх сонирхол надад ч байдаг. Компанийнхаа ирээдүйг өөдрөгөөр төсөөлж, хүссэн үр дүндээ ойрын жилүүдэд ойртохын тулд чармайж ажиллахыг хичээж байна.

Та бүхэнд асуулт байна уу? Байхгүй байна.

За одоо санал өгөх ажиллагааг эхлүүлье. Санал өгөхийн өмнө Тооллогын комиссын даргаас зөвлөмж, аргачлалыг өгнө.

Б.Юмжирдулам: Саналын хуудас 2 тусдаа байгаа. Эхнийх нь өмнө нь өгч байсан саналын хуудас тул та бүхэнд ойлгомжтой байх гэж бодож байна. Дараагийн саналын хуудсаар ТУЗ-ийн гишүүдийг сонгох асуудлаар санал авах юм.

“Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журмыг шинэчлэн батлах тухай” Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 880 дугаар тогтоол байна. Энэ журамд зааснаар бол хувьцаа эзэмшигч Та Хараат болон Ердийн гишүүнд нэр дэвшиж байгаа гэдгээс үл хамааран өөрийн саналаа Саналын хуудаст бичигдсэн хэнд ч өгч болно. Эзэмшиж байгаа хувьцааныхаа тоог 9-өөр үржүүлэхэд таны кумулятив саналын тоо гарна. Энэ гарсан тоогоо нэр дэвшигч нарт хуваахгүйгээр нэг нэр дэвшигчийн төлөө бүгдийг өгч болох юм байна.

СЗХ-ны тогтоолыг та нарт хувилж тараасан байгаа. Асууж, тодруулах зүйл байвал асууна уу?

Д.Батхуяг: Санал хураах ажил дууссан байна. Дүнгийн талаар Тооллогын комиссын дарга Б.Юмжирдулам танилцуулна.

Б.Юмжирдулам: Тооллогын дүнг хэлэлцсэн асуудал бүрээр танилцуулбал:

1. “Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай” асуудлаар:

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
10,480,354	96,9%	334,470	3.1%	-	-

2. “ТУЗ-ийн 2026 оны зардлын төсвийг батлах тухай” асуудлаар:

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
хувь	тоо	хувь	хувь	тоо	хувь
10,817,824	100%				

3. “ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай” асуудлаар

Санал өгсөн хувьцаа эзэмшигчид	Санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн хувьцааны тоо	Нийт саналын эрхийн тоо	Ердийн гишүүд						Хараат бус гишүүд					
			Д.Батхуяг	Л.Даваа	Д.Дуламсүрэн	М.Золзаяа	М.Зулзаяа	Б.Мандхай	П.Бат-Оргил	П.Баянсан	Ц.Наран-Учрал	О.Тунгалаг	Ш.Энхмэнд	Д.Энхтогтох
17	10,817,824	97,360,416	10,480,374	10,480,374	10,480,374	10,480,374	10,480,374	10,480,374	7,020	1,019,527	11,492,647	2,475,934	9,992,278	9,490,886

Хувьцаа эзэмшигчдийн санал өгсөн дүнгээс харахад ердийн гишүүд бүгд ижил хэмжээний санал авсан байна. Хараат бус гишүүнд нэр дэвшигчдээс Ц.Наран-Учрал, Ш.Энхмэнд, Д.Энхтогтох нар хамгийн олон санал авсан байна.

4. “ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын тухай” асуудлаар:

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
хувь	тоо	хувь	хувь	тоо	хувь
10,817,804	99,9998%			20	0,0002%

\ Тооллогын комиссын тогтоолыг хавсаргав.\

Д.Батхуяг: ХЭХ-аас гарах тогтоолын төслийг уншиж, батлуулъя.

Тогтоолын төсөл дээр өөр саналтай хүн байна уу? Байхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолуудыг батлав. Тус хурлаас нийт 4 тогтоол гарсан ба хувьцаа эзэмшигчид 100 хувийн саналаар батлав.

Хуралд идэвхтэй оролцсон хувьцаа эзэмшигчид Та бүхэндээ баярлалаа.

Хувьцаа эзэмшигчдийн хурал хаасныг мэдэгдье.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 12 цаг 45 минутад өндөрлөв.

ХЭХ-ЫН ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН
ХУРЛЫН ДАРГА
ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН ТУЗ-ИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Д.БАТХУЯГ

С.ОЮУНЭРЭЛ